

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

ТАРИМАЛ УРГАМЛЫН ШИНЭ СОРТЫГ НЭРИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь таримал ургамлын шинэ сортын нэрэнд тавигдах шаардлага, нэрийг бүртгүүлэхээр хүсэлт гаргах, нэрэнд шүүлт хийх, нэрийг хадгалах, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. СОРТЫН НЭРЭНД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. Таримал ургамлын шинэ сортын бүтээгч нь Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 12.3.2-т заасны дагуу өөрийн бүтээсэн шинэ сортдоо оноосон нэр өгнө.

2.2. Шинэ сортод өгсөн оноосон нэр нь Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан шаардлагыг хангасан байна:

2.2.1. санал болгосон нэр нь кирилл үг, үсэг, арав тоогоор илэрхийлэгдсэн байх;

2.2.2. гадаад үг, үсгээр илэрхийлэгдсэн сортын нэрийг кирилл үг, үсэгт шилжүүлсэнтэй нь хамт ирүүлэх;

2.2.3. шинэ сортын нэрийн эхэнд үг, үсгийн дараа нь тоон илэрхийлэл байх;

2.2.4. хуулиар хориглосон нэр байх;

2.2.5. шинэ сортын нэрийг үсгээр илэрхийлсэн бол томоор, үгээр илэрхийлсэн бол эхний үсэг нь томоор бичигдсэн байх.

-жишээлбэл: “Дархан 134”, “УБ 100” гэх мэт.

2.2.6. шинэ сортын нэр нь хоёр буюу түүнээс дээш холбоо үгээр илэрхийлэгдэх бол дараахь байдлаар бичигдсэн байх:

2.2.7.1. хоёр дахь үг нь гийгүүлэгчээр эхэлсэн бол түүнийг эхний үгийн араас шууд залгаж бичих;

-жишээлбэл: Улаанбаатар 312 гэх мэт.

2.2.7.2. хоёр дахь үг нь эгшгээр эхэлсэн бол эхний үгийн араас зураас /-/зурж томоор бичсэн байх

-жишээлбэл: Дархан-Уул 110 гэх мэт.

2.3. Шинэ сортын нэрийг 3 ба түүнээс дээш үгээр илэрхийлэхгүй.

3. ШИНЭ СОРТЫН НЭРИЙГ ХАДГАЛУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ

3.1. Шинэ сортыг бүтээгч нь шинэ сортын бүтээгчийн эрх авах тухай өргөдөл гаргахаас өмнө тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн шинэ сортыг нэрлэхээр санал болгож байгаа нэрэнд шүүлт хийлгэх, хадгалуулах тухай хүсэлтээ дор дурдсан бичиг баримтын хамт ирүүлнэ:

3.1.1. шинэ сорт болон түүнд санал оноосон нэрийн талаарх мэдээллийг энэ журмын маягт-1-ийн дагуу гаргах;

3.1.2. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 12.3.1-д заасан аж ахуй, биологийн үнэ цэнийг /VCU/ сорт сорилтын дүнгээр тогтоосныг нотлох баримт.

4. ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ БҮРТГЭХ

4.1. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.1-д заасан хүсэлтийг хүлээн авмагц дор дурдсан ажиллагаа явуулна:

4.1.1. хүсэлтийг хүсэлт бүртгэх дэвтэрт бүртгэж хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрт бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг сортын бүтээгчийг байлцуулан тэмдэглэж, энэ журмын маягт-2-т дурдсан тодорхойлолтыг сортын бүтээгчид өгөх;

4.1.2. тухайн өдөр хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэгдсэн хүсэлтэд тусгай тэмдэглэгээ хийх;

4.1.3. бүртгэсэн даруйд нь хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлах.

4.2. Нягтлах ажиллагаа дууссаны дараа энэ журмын 6 дугаар зүйлд заасны дагуу шүүлт хийнэ.

5. ШИНЭ СОРТЫН НЭРЭНД ШҮҮЛТ ХИЙХ, БАТАЛГААЖУУЛАХ

5.1. Шинэ сортын бүтээгчийн санал болгосон нэрэнд шүүлт хийх хугацаа нь хүсэлт гаргасан өдрөөс 3 сараас доошгүй байна.

5.2. Санал болгосон нэрийг хүсэлт гаргасан өдрөөс хойш 3 хоногийн дотор тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим хуудастаа энэ журмын 6.1-д заасан хугацаанд байршуулна.

5.3. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санал болгосон нэрийг дараахь аргаар шүүлт хийнэ:

5.3.1. үндэсний сортын бүртгэлээс шүүх;

5.3.2. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 14.11-т заасны дагуу шинэ сортын шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг харилцан хүлээн зөвшөөрөх талаар хамтран ажиллаж байгаа бусад орны эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

5.4. Санал болгосон сортын нэр нь дараахь болзлыг нэгэн зэрэг хангсан тохиолдолд тухайн нэрийг хадгалсныг баталгаажуулж энэ журмын маягт-2-ын дагуу баталгаажуулалтын хуудсыг олгоно:

5.4.1. шинэ сортын нэр нь үндэсний сортын бүртгэлд бүртгэлтэй бусад сортын нэртэй давхардаагүй нь тогтоогдвол;

5.4.2. санал болгосон сортын нэр нь энэ журмын 5.3.2-т заасан бусад улсад бүртгэлтэй сортын нэртэй давхцаагүй тухай хариу мэдэгдэл ирсэн бол.

5.5 Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь мэдээллийг цахим хуудастаа байршуулна:

5.5.1. Нэр баталгаажуулах тухай хүсэлтийн дугаар

5.5.2. Санал болгосон нэр

5.5.3. Хүсэлт гаргасан сортын бүтээгчийн нэр

5.4. Сортын бүтээгчийн эрхээр хамгаалуулах хүсэлт гаргасан сортын нэрс давхардсан тохиолдолд эхэлж мэдээлэгдсэн сортын нэр нь давуу эрхтэй.

5.5. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сүүлд мэдээлэгдсэн давхардсан санал болгосон нэрний оронд өөр нэрийг ажлын 10 хоногт багтаан санал болгохыг шаардана.

5.6. Санал болгосон сортын нэр нь өмнө гарсан, эсхүл хүсэлт гаргасан байгаа аливаа сортын нэртэй давхардсан тохиолдолд Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 16.3-т заасныг удирдлага болгон ажлын 10 хоногийн хугацаанд багтаан өөр нэр санал болгохыг сортын бүтээгчээс шаардана.

5.7. Энэ журмын 5.5 болон 5.6-т заасан хугацаанд өөр нэр санал болгоогүй бол хүсэлт гаргаагүйд тооцож, энэ талаар цахим хуудастаа мэдээлнэ.

5.8. Өөр нэр санал болгосон бол энэ журамд заасан шаардлагыг хангасныг нягтлах, цахим хуудаст мэдээлэх, шүүлт хийх, хадгалсныг баталгаажуулах ажиллагаа хийгдэнэ.

5.9. Гадаад үг, үсгээр илэрхийлэгдсэн сортын нэрийг кирилл үг, үсэгт шилжүүлсэнтэй нь хамт баталгаажуулж хадгална.

5.10. Шинэ сортын нэрийг монгол хэл рүү орчуулсан бол энэ журмын 5.9 дахь заалт хамаарахгүй.

6. ШИНЭ СОРТЫН НЭРИЙГ ХАДГАЛАХ ХУГАЦАА

6.1. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаажуулсан сортын нэрийг баталгаажуулсан өдрөөс эхлэн Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 16.4-т заасны дагуу сортын бүтээгчийн эрхийг олгох хүртэлх хугацаанд цахим бүртгэлд хадгална.

6.2. Шинэ сортын нэрийг хадгалсан талаарх мэдээллийг цахим хуудастаа байршуулж, энэ журмын 5.3.2-т заасны дагуу хамтран ажиллаж байгаа бусад орны эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

7. ШИНЭ СОРТЫН НЭРИЙГ БҮРТГЭХ

7.1. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 16.4-т заасны дагуу тухайн сортын бүтээгчийн эрх олгосон өдрөөр тухайн сортын нэрийг цахим бүртгэлд бүртгэнэ.

7.2. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 18.3-т заасны дагуу сортын бүтээгчийн эрх олгоогүй бол цахим бүртгэлээс хасна.

7.3. Энэ журмын 5.8-д заасны дагуу сортын гадаад нэрийг монгол хэлээр галиглан буулгасан бол түүнийг тухайн сортын нэртэй хамт бүртгэнэ.

7.4. Бүртгэсэн болон хассан сортын нэрийг цахим хуудастаа мэдээлэх ба энэ журмын 3.3.2-т заасны дагуу хамтран ажиллаж байгаа бусад орны эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

8. СОРТЫН НЭРИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

8.1. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 15.2-т заасны дагуу сортын бүтээгчийн эрх дуусгавар болсон нь сортын нэрийг ашиглах эрхийг хөндөхгүй.

9. СОРТЫН НЭРИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ

9.1. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сортын нэрийн цахим бүртгэл хөтөлж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулна.

9.2. Сортын нэрийн цахим бүртгэл нь нийтээд нээлтэй байна.

10. СОРТЫН НЭР АШИГЛАХ

10.1. Сортын бүтээгч нь Таримал ургамлын үр, сортын тухай хуульд заасны дагуу сортын нэрээ ашиглах эрхтэй.